

Огноо: 2025.08.15

Баримт бичгийн төрөл: Тушаалын төсөл

Товч утга: “Автомат клиринг хаус системийн дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

“Автомат клиринг хаус системийн дүрэм”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.3 дахь хэсгийн 6.3.3, 6.3.4 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-128 тоот тушаалаар батлагдсан “Автомат клиринг хаус системийн дүрэм”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1. Дүрмийн 9 дүгээр зүйлд дараах заалтыг шинэчлэн найруулсугай.

1/ 9.4.5 дахь заалт: “ҮЦГТ нь энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан буцаалтын эсхүл татгалзсан кредит гүйлгээг үр дүнгийн тооцоололд тусгахгүй бөгөөд үүнээс үүдэн гарсан санхүүгийн болон санхүүгийн бус хохирлыг хариуцахгүй болно.”

2. Дүрмийн 9 дүгээр зүйлд дараах заалтуудыг нэмсүгэй.

1/ 9.6 дахь заалт: “Нэхэмжлэл хүлээн авч байгаа оролцогч нь дараах зарчмыг баримтална.”

2/ 9.6 дахь хэсгийн 9.6.1 дэх заалт: “Нэхэмжлэлийн хүсэлтийг тухай бүр хэрэглэгчид мэдэгдэнэ.”

3/ 9.6 дахь хэсгийн 9.6.2 дахь заалт: “Хэрэглэгчийн сонголтоор нэхэмжлэлийн дагуу гүйлгээ илгээх эсхүл нэхэмжлэхээс татгалзах хариуг тухай бүр өгнө.”

4/ 9.6 дахь хэсгийн 9.6.3 дахь заалт: “Хэрэглэгч нь нэхэмжлэлийн хүсэлтэд 3 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд тухайн нэхэмжлэлийг хүчингүй болгоно.”

5/ 9.6 дахь хэсгийн 9.6.4 дэх заалт: “Нэхэмжлэлийн хүсэлтийг илгээхээс өмнө тухайн хэрэглэгчид нэхэмжлэл хүлээн авагчийн Дансны нэгдсэн сан дахь мэдээллийг харуулж, баталгаажуулна.”

3. Дүрмийн 9, 10 дугаар зүйлийн дараах заалтуудыг хүчингүй болгосугай.

1/ “Автомат клиринг хаус системийн дүрэм”-ийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт: “ҮЦГТ нь энэ дүрмийн 9.4.5-д заалтад заасан үйл ажиллагаанаас гарсан санхүүгийн болон санхүүгийн бус хохирлыг хариуцахгүй”;

2/ 10.9 дэх хэсгийн 10.9.1 дэх заалт: “Хэрэглэгчийн нэрийн эхний болон сүүлийн үсгийг нууцлахгүй байх”;

3/ 10.9 дэх хэсгийн 10.9.2 дахь заалт: “Хэрэглэгчийн нэрийг 1 үсэг алгасах зарчмаар нууцлах (тэгш үсгээр бүрдсэн бол сүүлийн үсгийн өмнөх хоёр үсгийг нууцлана)”;

4/ 10.9 дэх хэсгийн 10.9.3 дахь заалт: “Хоёр үсэгнээс бүрдсэн хэрэглэгчийн нэрийг нууцлахад 10.9.2 дахь заалт хамаарахгүй бөгөөд эхний үсгийг харуулж, хоёр дахь үсгийг нууцлах”;

5/ 10.9 дэх хэсгийн 10.9.5 дахь заалт: “Аж ахуй нэгжийн нэрийг нууцлахгүй бүтнээр харуулдаг байх”.

2. Батлагдсан тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Автомат клиринг хаус системийн нийт оролцогч нарт тус тус даалгасугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т тус тус үүрэг болгосугай.

4.Батлагдсан тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хууль, эрх зүйн газар (Д.Аюуш), Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН